



**ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ  
ХУВЬЦААТ КОМПАНИ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
1 дүгээр хөрөө, Жигжиджавын гудамж 8, Финанс ттк  
Утас: 7505-5355

И-мэйл: info@erdenestt.mn, Вэбсайт: www.ett.mn

2023.10.25

№

01/1842

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тодруулгын хариу хүргүүлэх тухай**

“Эрдэнэс Тавантолгой” ХК-аас зарласан ЭТТХК/202302001 дугаартай “Цанхийн баруун уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажил”-ын 1 дүгээр багцын гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтад тендерт оролцохыг сонирхогч этгээдээс тодруулга ирүүлсэн байна. Иймд тодруулгын хариуг хүргүүлж хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичгийн ТШЗ-н 17.6.3-т заасан техник тоног төхөөрөмжүүд нь банк болон банк бус компанийн барьцаанд байгаа бол тус газруудаас тендерт оролцогчийн өмч болохыг тодорхойлсон тодорхойлолтыг, гэрээний хамт ирүүлнэ.

2. Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, машин механизмын эзэмшигчийн талаарх мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-ээр дамжуулан шалгах тул худалдах, худалдан авах зэрэг гэрээгээр шинэ техник тоног төхөөрөмж худалдан авсан, техник тоног төхөөрөмж тээвэрлэлтийн замдаа ирж байгаа тохиолдлыг үнэлгээнд харгалзан хянан үзэхгүй болохыг мэдэгдэж байна.

3. Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн техникийн /экскаватор/ албан ёсны үйлдвэрлэгчээс гаргасан техникийн үзүүлэлт бүхий каталог танилцуулгыг ирүүлэх шаардлагатай бөгөөд тухайн мэдээлэлд санал болгож буй техникийн дээд, доод хязгаарыг заасан үзүүлэлтүүд тусгагдсан байх шаардлагатай.

4. Тендерийн баримт бичгийн тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 12.1-д “Тендерийн хэл нь Монгол хэл байна, гадаад хэл дээрх бүх материалыг орчуулгын хамт ирүүлнэ, Анхааруулга: Орчуулга хийгдээгүй гадаад хэл дээрх материалыг ирүүлээгүйд тооцох ба уг тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу.” гэж заасан.

5. Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн автосамосвал нь 50 тонн болон түүнээс дээш тонны даацтай байна.

6. Тендерийн баримт бичгийн ТШЗ-н 17.6.2-т “Тухайн инженер, техникийн ажилтны мэргэжлээрээ ажилласан жилийн туршлагыг баталгаажуулахын тулд шаардсан жилийн нийгмийн даатгал төлсөн цахим тодорхойлолт хавсарган ирүүлнэ...” гэж заасан. Дээрх тодорхойлолтын зөвхөн цалингийн хэсгийг нууцлах боломжтой.

7. Ажил гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөц нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байх шаардлагатай бөгөөд нийт ажлын туршлагыг шаардсан жилийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн төлөлтөөр баталгаажуулна.

8. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу тендерт оролцогчдод давуу эрх олгоно.

0400003511

Хавсралтаар үнийн тохируулга хийх нөхцөлийг хүргүүлж байна.

Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 10.3-т заасны дагуу дээрх нэмэлт өөрчлөлтүүд нь тендерийн баримт бичгийн салшгүй нэг хэсэг болно.

Хавсралт 1 хуудастай.

ЗАСГИЙН ГАЗРЫН ОНЦГОЙ  
БҮРЭН ЭРХТ ТӨЛӨӨЛӨГЧ



Ж.ГАНБАТ

**ҮНИЙН ТОХИРУУЛГА ХИЙХ АРГАЧЛАЛ**

/Хөрс хуулалт, нүүрс олборлолт/

Шатахууны үнийн өсөлт нь  $\pm 10$  хувиас дээш үед үнийн тохируулга хийнэ.

Үнийн тохируулга хийх аргачлалыг доорх томъёоллоор тооцсон.

$$P = (P_c * (\frac{A * F_1}{F_0} + \frac{D * K_1}{K_0} + B * (1 + CPI) + C))$$

**Тайлбар:**

- P** Тохируулсан үнэ
- P<sub>c</sub>** Гэрээний үнэ буюу тендерт санал болгосон үнэ /НӨАТ багтсан үнэ/
- A** Нийт зардалд шатахууны зардлын эзлэх хувь - 40%
- B** Нийт зардалд инфляцийн эзлэх хувь - 10%
- D** Нийт зардалд ханшийн зөрүүний зардлын эзлэх хувь-25%
- C** Нийт зардалд тогтмол зардлын эзлэх хувь - 25%
- F<sub>1</sub>** Үнийн тохируулга хийх сарын үнэ байна.  
Тус үнийг “Эрдэнэс Тавантолгой” ХК болон туслан гүйцэтгэгч компаниудын түлш худалдах, худалдан авах гэрээ, ирүүлсэн нэхэмжлэх, төлбөр шилжүүлсэн баримт, тооцоо нийлсэн актын мэдээлэлд үндэслэнэ. /Өмнөговь аймаг дахь НӨАТ багтсан түлшний үнэ/
- F<sub>0</sub>** Түлшний суурь үнэ нь гэрээ байгуулсан компанийн тендерийн баримт бичгийг нээсэн үеийн үнэ байна. Тохируулга өмнө нь хийгдсэн бол тухайн тохируулга хийсэн үеийн үнэ байна. /Тус үнийг “Эрдэнэс Тавантолгой” ХК болон туслан гүйцэтгэгч компаниудын түлш худалдах, худалдан авах гэрээ, ирүүлсэн нэхэмжлэх, төлбөр шилжүүлсэн баримт, тооцоо нийлсэн актын мэдээлэлд үндэслэнэ. /Өмнөговь аймаг дахь НӨАТ багтсан түлшний үнэ/
- K<sub>1</sub>** Тохируулга хийх тухайн сарын Монгол банкнаас гаргасан ам.долларын ханшийн арифметик дундаж
- K<sub>0</sub>** Гэрээ байгуулсан компанийн тендерийн баримт бичгийг нээсэн үеийн Монгол банкнаас гаргасан ам.долларын ханшийн тухайн сарын арифметик дундаж байна. Тохируулга өмнө нь хийгдсэн бол тухайн тохируулга хийсэн сарын Монгол банкнаас гаргасан ам.долларын ханшийн арифметик дундаж байна.
- CPI** Хагас жилийн инфляцийн түвшин (Тохируулга хийх жилийн эхний зургаан сарын инфляцийн түвшин өссөн дүнгээр байна. Жишээлбэл 2021 оны 07.01-ны өдөр тохируулга хийвэл 2021 оны 01.01-ээс 07.01-ийг хүртэлх өссөн дүн байна)